

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 24 оны 05 сарын 31 өдөр

№ R-2024-28

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ХасБанк ХК ("ХасБанк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдрөөс 30-ны өдрийн хооронд зохион байгуулсан цахим санал хураалтаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- ХасБанкны холбогдох этгээд болох МСМ Групп ХХК ("Зээлдэгч") нь эргэлтийн хөрөнгийн зориулалтаар, дараах үндсэн нөхцөл бүхий зээлийн шугамын гэрээнүүд ("Зээлийн шугам")-ийг байгуулахаар ХасБанктай харилцан тохиролцсоныг:

Зээлийн шугам:

Нийт дүн:	7,000,000,000 төгрөг
Хугацаа:	24 сараар сунгах
Хүү:	15.6% /жилийн
Үүрэг хүлээсний шимтгэл:	2.0%
Зээлийн ангилал:	Хэвийн /0.5%
Зээлийн нөхцөл:	Нүүр хуудаст тусгагдсаны дагуу

Олон талт шугам:

Нийт дүн:	12,000,000,000 төгрөг
Хугацаа:	24 сараар сунгах
Хүү:	15.6% /жилийн
Үүрэг хүлээсний шимтгэл:	2.0%
Зээлийн ангилал:	Хэвийн /0.5%
Зээлийн нөхцөл:	Нүүр хуудаст тусгагдсаны дагуу

Кредит карт:

Нийт дүн:	80,000 ам.доллар
Хугацаа:	24 сараар сунгах
Хүү:	20.4% /жилийн
Зээлийн ангилал:	Хэвийн /0.5%
Зээлийн нөхцөл:	Нүүр хуудаст тусгагдсаны дагуу

2. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо (“ЭУХ”) ТУЗ-ийн цахим санал хураалттай нэгэн зэрэг зохион байгуулсан цахим санал хураалтаар Зээлийн шугамыг батлах саналыг ТУЗ-д хүргүүлсэнийг;
3. Зээлийн шугам нь Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1.2 дахь заалтад заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл болохыг;
4. Зээлийн шугам нь Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэг, батлах үйл ажиллагаа нь Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт тус тус нийцсэн болохыг; болон
5. ТУЗ нь Зээлийн шугамыг ЭУХ-ны санал болгосны дагуу батлах хүсэлтэй байгааг тус тус дурдав.

ТОГТООХ нь:

1. Зээлийн шугамыг үүгээр баталсугай.
2. Зээлдэгчийн нийт үүргийн хэмжээг 19,270,100,000 төгрөгөөс хэтрүүлэхгүйгээр Зээлийн шугамын дагуу зээл хүсэлт шийдвэрлэж олгох эрхийг ХасБанкны Зээлийн удирдлагын хороо (“ЗУХ”)-нд олгосугай.
3. Энэхүү Тогтоол гарсан өдрөөс эхлэн 12 сарын хугацаанд Зээлдэгчийн хүсэлтээр банкнаас өгөх бүх төрлийн зөвшөөрөл олгох, шаардлагатай тохиолдолд Зээлийн шугамын гэрээний дагуу олгогдсон зээлийн нөхцөл өөрчлөх асуудлыг ХасБанкны ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэрлэх эрхийг ЗУХ-нд олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.МӨНХЦЭЛМЭГ